

# ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 24 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/089/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.Shinjenmagadlahui ezshaudit.mn Улаанбаатар хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: <a href="mailto:Munkhbayarsh@audit.gov.mn">Munkhbayarsh@audit.gov.mn</a> Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: <a href="mailto:Batsurenu@audit.gov.mn">Batsurenu@audit.gov.mn</a> Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: <a href="mailto:Battsetsegs@audit.gov.mn">Battsetsegs@audit.gov.mn</a> Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: <a href="mailto:Shinjenmagadlahui.audit@gmail.com">Shinjenmagadlahui.audit@gmail.com</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>Асуудлыг онцолсон хэсэг</b> .....	3
<b>Аудитын гол асуудал</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	10
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	15
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	15
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	16
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	16
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	16
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	16
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	17
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	17
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	17
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	17
<b>5.1 Төлбөрийн акт</b> .....	
<b>5.2 Албан шаардлага</b> .....	
<b>5.3 Зөвлөмж</b> .....	
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	

### **Товчилсон үгийн жагсаалт**

<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>ТӨБЗГ</b>	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>ИТХ</b>	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН  
24 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Л.СУВДАНЧИМЭГ ТАНАА**

*Л.Сувданчимэг* № 99

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 24 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Усын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 24 дүгээр цэцэрлэгийн 2024 оны нийт төсвийн зарцуулалт тайлант онд хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 83,3 хувийн биелэлттэй байгаа нь 12 дугаар сарын 28-ны өдөр цалингийн зардалд 95,707.9 мянган төгрөгний санхүүжилт нэмэгдэн орж ирсэнтэй холбоотой байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4525020155

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр тус цэцэрлэгийн цалингийн зардал 652,711.2 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 40.1 хувиар өссөн байна.

### **Бусад асуудал**

Дархан сумын 24 дүгээр цэцэрлэг нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилго бүхий 79 ажил төлөвлөж, 100 хувийн биелэлттэй ажилласан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**



**Ш.МӨНХБАЯР**

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	165,122,363.24	237,932,259.13
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	111,692,383.04	171,990,695.23
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	111,692,383.04	171,990,695.23
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	111,692,383.04	171,990,695.23
31211	Төрийн сангийн харилцах	111,692,383.04	171,990,695.23
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	53,429,980.20	65,941,563.90
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	833,850.00	666,900.00
35130	Эм боох материал	833,850.00	666,900.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	52,596,130.20	65,274,663.90
35410	Бичиг хэргийн материал	1,554,000.00	2,702,000.00
35420	Аж ахуйн материал	38,885,397.10	51,419,747.10
35460	Хүнсний материал	12,156,733.10	11,152,916.80
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,674,649,626.45	1,666,913,490.52
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,674,649,626.45	1,666,913,490.52
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,494,675,326.45	1,486,939,190.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,596,717,139.00	1,596,717,139.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(166,853,702.03)	(193,886,487.71)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,887,763.75	95,176,263.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,549,508.92)	(48,149,785.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,850,306.63	54,850,306.63
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,559,097.58)	(38,412,751.50)
39214	Бусад үндсэн хөрөнгө	65,626,892.00	65,626,892.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(39,610,466.40)	(45,148,386.36)
39217	Ном	166,000.00	166,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	179,974,300.00	179,974,300.00
39301	Програм хангамж	2,279,300.00	2,279,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,155,000.00)	(1,155,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	178,850,000.00	178,850,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	1,839,771,989.69	1,904,845,749.65
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	1,839,771,989.69	1,904,845,749.65
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	178,850,000.00	178,850,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,660,921,989.69	1,725,995,749.65
51210	Өмнөх үеийн үр дүн	1,660,921,989.69	1,660,921,989.69
51220	Тайлант үеийн үр дүн	-	65,073,759.96
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	1,839,771,989.69	1,904,845,749.65



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	764,868,380.00	994,440,300.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	7,849,680.00	35,129,500.00
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,849,680.00	35,129,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,849,680.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,849,680.00	-
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	35,129,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	757,018,700.00	959,310,800.00
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	723,827,100.00	916,300,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	723,827,100.00	916,300,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	33,191,600.00	43,010,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,191,600.00	43,010,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	714,087,492.99	929,366,540.04
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	714,087,492.99	929,366,540.04
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	713,006,928.68	927,267,888.73
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	466,075,763.53	652,711,206.00
210101	Үндсэн цалин	286,235,432.47	467,363,328.90
210102	Нэмэгдэл	159,657,523.06	168,363,063.00
210104	Урамшуулал	20,182,808.00	16,984,814.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	69,055,700.00	82,727,700.81
210201	Тэтгэврийн даатгал	46,957,500.00	57,348,149.68
210202	Тэтгэмжийн даатгал	5,524,700.00	6,747,319.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,419,600.00	3,402,791.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,104,800.00	2,914,516.17
210205	Эрүүл мэндийн даатгал	11,049,100.00	12,314,924.34
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,811,035.69	28,911,348.69
210301	Гэрэл, цахилгаан	10,286,282.48	10,543,948.20
210302	Түлш, халаалт	11,135,912.39	10,813,775.72
210303	Цэвэр, бохир ус	9,388,840.82	7,553,624.77
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,248,600.00	3,727,400.00
210401	Бичиг хэрэг	3,339,600.00	1,649,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	288,500.00	179,300.00
210408	Бараа материал акталсны зардал	5,620,500.00	1,898,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	75,094,941.60	92,395,397.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	174,000.00	474,946.00
210502	Хоол, хүнс	74,920,941.60	91,920,451.30
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,686,530.00	12,000,000.00
210604	Урсгал засвар	9,686,530.00	12,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,411,700.00	3,813,100.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	907,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,411,700.00	2,905,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>51,622,657.86</b>	<b>50,981,735.93</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,112,400.00	5,750,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,206,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,510,257.86	44,024,635.93
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,080,564.31</b>	<b>2,098,651.31</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,080,564.31</b>	<b>2,098,651.31</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,080,564.31	2,098,651.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>50,780,887.01</b>	<b>65,073,759.96</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>50,780,887.01</b>	<b>65,073,759.96</b>



## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	764,868,380.00	959,310,800.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	7,849,680.00	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,849,680.00	-
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	7,849,680.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,849,680.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	757,018,700.00	959,310,800.00
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	723,827,100.00	916,300,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	723,827,100.00	916,300,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	33,191,600.00	43,010,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,191,600.00	43,010,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	671,045,123.53	897,853,487.81
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	671,045,123.53	897,853,487.81
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	669,964,559.22	895,754,836.50
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	466,075,763.53	652,711,206.00
210101	Үндсэн цалин	286,235,432.47	467,363,328.90
210102	Нэмэгдэл	159,657,523.06	168,363,063.00
210104	Урамшуулал	20,182,808.00	16,984,814.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	69,055,700.00	82,727,700.81
210201	Тэтгэврийн даатгал	46,957,500.00	57,348,149.68
210202	Тэтгэмжийн даатгал	5,524,700.00	6,747,319.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,419,600.00	3,402,791.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,104,800.00	2,914,516.17
210205	Эрүүл мэндийн даатгал	11,049,100.00	12,314,924.34
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,811,035.69	28,911,348.69
210301	Гэрэл, цахилгаан	10,286,282.48	10,543,948.20
210302	Түлш, халаалт	11,135,912.39	10,813,775.72
210303	Цэвэр, бохир ус	9,388,840.82	7,553,624.77
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	76,436,220.00	90,916,635.00
210502	Хоол, хүнс	76,436,220.00	90,916,635.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,300,000.00	12,000,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	12,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,411,700.00	2,905,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,411,700.00	2,905,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	24,874,140.00	25,582,046.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,639,140.00	16,616,296.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,235,000.00	8,965,750.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,080,564.31	2,098,651.31

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,080,564.31	2,098,651.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,080,564.31	2,098,651.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	93,823,256.47	61,457,312.19
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	2,220,750.00	1,159,000.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	2,220,750.00	1,159,000.00
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	2,220,750.00	1,159,000.00
222001	Тоног төхөөрөмж		1,159,000.00
223001	Бусад хөрөнгө	2,220,750.00	-
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(2,220,750.00)</b>	<b>(1,159,000.00)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	91,602,506.47	60,298,312.19
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	20,089,876.57	111,692,383.04
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	111,692,383.04	171,990,695.23



## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	178,850,000.00	-	1,610,141,102.68	1,788,991,102.68
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>178,850,000.00</b>	-	1,610,141,102.68	1,788,991,102.68
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	50,780,887.01	50,780,887.01
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>178,850,000.00</b>	-	<b>1,660,921,989.69</b>	1,839,771,989.69
<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>178,850,000.00</b>	-	<b>1,660,921,989.69</b>	1,839,771,989.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>178,850,000.00</b>	-	<b>1,660,921,989.69</b>	1,839,771,989.69
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	65,073,759.96	65,073,759.96
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>178,850,000.00</b>	-	<b>1,725,995,749.65</b>	1,904,845,749.65



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ  
/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,076,772,300.00	896,913,836.50	(179,858,463.50)	83.30
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,076,772,300.00	896,913,836.50	(179,858,463.50)	83.30
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,076,772,300.00	896,913,836.50	(179,858,463.50)	83.30
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	800,454,200.00	652,711,206.00	(147,742,994.00)	81.54
210101	Үндсэн цалин	589,935,400.00	467,363,328.90	(122,572,071.11)	79.22
210102	Нэмэгдэл	199,539,300.00	168,363,063.00	(31,176,237.00)	84.38
210104	Урамшуулал	10,979,500.00	16,984,814.10	6,005,314.10	154.70
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	92,253,800.00	82,727,700.81	(9,526,099.19)	89.67
210201	Тэтгэврийн даатгал	62,734,600.00	57,348,149.68	(5,386,450.32)	91.41
210202	Тэтгэмжийн даатгал	7,378,400.00	6,747,319.38	(631,080.62)	91.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,690,000.00	3,402,791.24	(287,208.76)	92.22
210204	Ажилгүйдлийн даатгал	3,690,000.00	2,914,516.17	(775,483.83)	78.98
210205	Эрүүл мэндийн даатгал	14,760,800.00	12,314,924.34	(2,445,875.66)	83.43
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,779,900.00	28,911,348.69	(7,868,551.31)	78.61
210301	Гэрэл, цахилгаан	13,400,000.00	10,543,948.20	(2,856,051.80)	78.69
210302	Түлш, халаалт	14,349,900.00	10,813,775.72	(3,536,124.28)	75.36
210303	Цэвэр, бохир ус	9,030,000.00	7,553,624.77	(1,476,375.23)	83.65
2105	<b>Нормативт зардал</b>	99,564,300.00	90,916,635.00	(8,647,665.00)	91.31
210502	Хоол, хүнс	99,564,300.00	90,916,635.00	(8,647,665.00)	91.31
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,000,000.00	12,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	12,000,000.00	-	100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,932,500.00	2,905,900.00	(26,600.00)	99.09
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,932,500.00	2,905,900.00	(26,600.00)	99.09
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	32,787,600.00	26,741,046.00	(6,046,554.00)	81.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,821,800.00	17,775,296.00	(6,046,504.00)	74.62
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,965,800.00	8,965,750.00	-	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,076,772,300.00	957,212,148.69	(119,560,151.31)	88.90

1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	916,300,800.00	916,300,800.00	-	100.0 0
131001	Улсын төсвөөс санхүүжих	916,300,800.00	916,300,800.00	-	100.0 0
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	48,779,900.00	40,911,348.69	(7,868,551.31)	83.87
132001	Орон нутгийн төсвөөс	48,779,900.00	40,911,348.69	(7,868,551.31)	83.87
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	111,692,383.04	111,692,383.04	
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	171,990,695.23	171,990,695.23	
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	-	100.0 0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0 0
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	33.00	32.00	(1)	96.97
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0 0
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	13.00	(1)	92.86
620003	Үйлчлэх ажилтан	18.00	18.00	-	100.0 0
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	250.00	152.00	(98.00)	60.80
631	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	250.00	152.00	(98.00)	60.80
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	250.00	152.00	(98.00)	60.80
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	33.00	32.00	(1)	96.97
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	20.00	19.00	(1)	95.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	-	100.0 0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12.00	12.00	-	100.0 0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 24 дүгээр цэцэрлэг нь "Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан цэцэрлэгийн менежментийг сайжруулах" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

- Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх боловсролын хууль, ерөнхий боловсролын тухай хуулийг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, багш ажилтан, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, тэдний оролцоотой хэрэгжүүлэх

- 5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулан сургуульд элсэн суралцах бэлтгэл хангах /хувилбарт сургалт/
- Хүүхэд бүр гэртээ ойр байрлах цэцэрлэгт хамрагдах хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх
- Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан хөгжлийн хоцрогдлыг нөхөх, арилгах, хүүхдийн хөгжилд ахиц гаргах
- Хүүхдийн IQ, EQ сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэх ухаанч мэдлэг олгох, нэгдмэл агуулга бүхий төсөлт ажлыг анги бүлгээс үл хамааран багаар хамтран гүйцэтгүүлж үр дүнг улирал бүр тооцох
- Цэцэрлэгт суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгох, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний цахим системийг ашиглан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, багшийн ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулан сургах, орчинг нь бүрдүүлэх, тэдэнд нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх
- Цэцэрлэгийн орчинд аливаа хэлбэрийн гадуурхал, дээрэлхэлт үүсэхээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хөгжлийн багийн үйл ажиллагааг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, үр дүнг тооцох
- Онцгой байдлын үед хүүхэд өөрийгөө болон бусдыг хамгаалах, мэдлэг сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, аливаа гамшгийн эрсдлийг даван туулах, чадарыг хөгжүүлэх
- Цэцэрлэгийн номын сангийн үйлчилгээг сурах, сургах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн сурч хөгжих, төлөвших, хамтран ажиллах, мэдээлэл авахад нь туслах орчин болгон өөрчилж нээлттэй байдлыг хангах

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн журам шинэчлэн батлах тухай” тушаалыг 2024 оны 01 сарын 01-ны өдрөөс мөрдөж ажиллах
- Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 12 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх
- Монгол улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоол “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”-ыг мөрдөж эхэлсэн,
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” 39 дүгээр тогтоол хэрэгжиж эхэлсэн,

- Монгол улсын засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 104 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болорвсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам” батлагдсан,
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавралт өөрчлөн батлах тухай” 84 дүгээр тогтоол батлагдаж зарим албан тушаалын ангилал, зэрэглэл өөрчлөгдсөн,
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ыг мөрдөж эхэлсэн,
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”,
- Монгол улсын засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүрийг шинэчлэн батлах тухай” 53 дугаар тогтоолыг мөрдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймаг Дархан сумын 24 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал байна гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн бэлтгэсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 24 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУЗГ-ын 128 дугаар тогтоолын дагуу өөрчлөлт орсон.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,073.7 мянган төгрөгөөр буюу 3.53 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	111,692.4	171,990.7	60,298.3
Авлага	-	-	-
Бараа материал	53,430.0	65,941.5	12,511.5
Үндсэн хөрөнгө	1,674,649.6	1,666,913.5	(7,736.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,839,772.0</b>	<b>1,904,845.7</b>	<b>65,073.7</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	178,850.0	178,850.0	-
Хуримтлагдсан үр дүн	1,660,922.0	1,725,995.7	65073.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,839,772.0</b>	<b>1,904,845.7</b>	<b>65,073.7</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 171,990.7 мянган төгрөг болж өмнөх оноос 60,298.3 мянган төгрөгөөр буюу 54 хувиар өссөн нь тухайн байгууллагын цалингийн сангаас 147,743.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 9,526.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 7,868.5 мянган төгрөг, хүүхдийн хоол хүнсний зардлаас 8,647.7 мянган төгрөг, мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас 26.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 6,046.0 мянган төгрөгийг хэмнэж ажилласантай холбоотой байна. Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Дархан-Уул аймийн 24 дүгээр цэцэрлэг нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өр, авлага гаргаагүй ажилласан.

Бараа материалын дансны үлдэгдэл 65,941.5 мянган төгрөг болж 12,511.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 4,003.1 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 12,000.0 мянган төгрөгийн барилгын засварын материал, 90,916.6 мянган төгрөгийн хүнсний материал, 308.0 мянган төгрөгийн эм боох материал, 14,612.8 мянган төгрөгийн аж ахуйн бараа материал нийт 121,840.6 мянган төгрөгийг орлогоор бүртгэж үйл ажиллагаандаа 107,430.3 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,666,913.5 мянган төгрөг болж 7,736.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 1,159.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 17,890.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар, 17,239.5 мянган төгрөгний үндсэн хөрөнгийг БЕГазраас шилжүүлэн авсан бөгөөд 44,024.6 мянган төгрөгөөр элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,904,845.7 мянган төгрөг болж 65,073.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 715,515.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 83,153.1 мянган төгрөг нийт 798,668.9 мянган төгрөгөөр, улсын төсвийн зарлагыг 715,515.8 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн зарлагыг 83,153.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсөв 770,530.5 мянган төгрөг буюу 55,014.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, орон нутгийн төсөв 48,779.9 мянган төгрөг буюу 34,373.2 мянган төгрөгөөр хасагдаж нийт 819,310.4 мянган төгрөгөөр буюу 20,641.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь Засгийн газрын тогтоолоор цалин хөлс нэмэгдсэн, багшийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгосон зэргээс шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвийг 145,770.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,076,772.3 мянган төгрөгийг улсын болон орон нутгийн төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 916,300.8 мянга, орон нутгийн төсвөөс 43,010.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилтээс 2,098.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 896,913.8 мянган төгрөг буюу 83.30 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 70,558.4 мянган төгрөгний хэмнэлттэй ажиллаж, оны эцэст 101431,6 мянган төгрөгний санхүүжилт нэмэгдэж, орон нутгийн төсвөөс 7,868.6 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80233 – Хүүхэд хамгаалал	1,392.3	1,392.0	(0.3)	99.98%
2	81605 - Эрүүл мэндийг дэмжих	3,508.1	1,684.0	(1,824.1)	48.00%
3	81807-Хүүхдийн хоол	99,564.3	90,916.6	(8,647.7)	91.31%
4	81816 - Хүүхдийн зэлтэй сургалтын орчин	3,681.2	3,681.2	0.0	100%
5	81823 - Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	2,053.6	750.0	(1,303.6)	36.52%
6	81834 -Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	907,886.6	747,943.5	(159,943.1)	82.38%

7	81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах	9,906.3	9,635.2	(271.1)	97.26%
8	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	48,779.9	40,911.3	(7,868.6)	83.87%
	Нийт дүн	1,076,772.3	896,913.8	(179,858.5)	83.30%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д “Ахмадын сан” байгуулах хуулийн хэрэгжилтийн биелэлт байхгүй байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөрийн арга хэмжээ хэрэгжээгүй байна.

### Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу 99,564.3 төгрөгийн төсөвт өртгөөр хүүхдийн хоол хүнсний тендерийг .... удаа зохион байгуулж Тендерт оролцогч ирээгүй учир шууд худалдан авалтыг зохион байгуулж харилцагч байгууллагуудаас үнийн санал авч харьцуулалтын арга ашиглан аль бага үнийн саналтай байгууллагуудтай гэрээ байгуулан ажилласан. 2024 оны 10-р сараас ерөнхий гэрээгээр “Мон-Мийт” ХХК шалгаран гэрээ байгуулан мах, махан бүтээгдэхүүний худалдан авалт хийж ажилласан.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 24 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийн тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-ийн аудитор Б.Хоролбат

гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 24 дүгээр цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 929,366.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 18,587.3 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 24 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 61561,2 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлыг 6,046.5 мянган төгрөг, хүүхдийн хоолны зардлыг 8647,7 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардлыг 26,6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 7868,6 мянган төгрөг буюу нийт 84150,6 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Мөн Засгийн газрын 2024 оны 12 сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сараас цалин хөлс 6 хувиар нэмэх шийдвэрээр 95707,9 төсөв нэмж өгснөөс шалтгаалсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамааруулан шалгалаа.

Тайлант хугацаанд боловсролын байгууллагын 2024 онд мэдээлбэл зохих 171 мэдээллээс 165 мэдээллийг хугацаандаа оруулж, 2 мэдээллийн хугацаа хоцорч, 4 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, мэдээллийн хэрэгжилт 98,8 хувьтай байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Дархан сумын 24 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийж, нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг үзэж шалгасан ба аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар санхүүгийн тайлангаар 2 зөвлөмж өгсөн зөрчил илэрсэн ба хэрэгжилтийг шалгахад 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	1,771.0	2	1,771.0	100.0
Нийт дүн	2	1,771.0	2	1,771.0	100.0

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын даргын тушаалаар 2024 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр 770,530.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж ирсэн. 2024 оны 12 дугаар сард тодотголоор 101,431.6 мянган төгрөгөөр төсөв нэмэгдэн орж ирсэнийг зарцуулаагүйгээс харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл 89,0 хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Тайлангийн 4.4.1, 4.4.2 дахь хэсэгт дурдсан Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга

хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй	1	0.0					1	0.0
Дүн	1	0.0					1	0.0

ААБ 5.5: АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Дархан-Уул аймгийн Дархан сумын 24 дүгээр цэцэрлэг  
Тайлант хугацаа: 2024 он

Хүснэгт Б. Санхүүгийн тайлангийн түвшинд болон ач холбогдолтой бий АГАДУТ-ыг үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх Шалгуур үзүүлэлт

№	Тодорхойлсон эрсдэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөж тооцох эсэх	Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт				
							Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл
1	Санхүүгийн тайланг УСНББОУС болон Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан шаардлагууд болон Сангийн яамнаас гаргасан заавар журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй байх	Тайлант онд батлагдсан төсвөөс ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй байна.	-	Тийм	Үгүй	УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга	Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын 1.1, 1.2, 1.3, 2.1.1 дэх заалтуудтай нийцэхгүй байна.	Хууль тогтоомжийн заалттай холбоотой асуудал.	Зөвлөмж		
Дүн											

Бэлтгэсэн:  
Аудитор

Б.Хоролбат  
огноо:

Хянасан:

Чанарын хяналтын менежер  
Л.Магсаржалан  
Огноо:

Шинжлэн магадлах эрх бүхий аудит ХХК-ийн захирал  
С.Оргил  
Огноо:

Танилцаж, зөвшөөрсөн

Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар цэцэрлэг

Дарга

Л.Сувданчимэг

Нягтлан бодогч

Д.Оюунчимэг

Огноо:

Огноо: